

Хот байгуулалт, барилга, нийтийн аж ахуйн салбарт
хөнгөлөлт эдлэх бүтээн байгуулалт, төсөл,
үйл ажиллагаанд тавигдах
шаардлага батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.11-д заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Хот байгуулалт, зураг төсөл, нийтийн аж ахуй, барилга угсралт, барилгын материал үйлдвэрлэлийн чиглэлээр бүтээн байгуулалт, төсөл, үйл ажиллагаанд оруулсан хөрөнгө оруулалт, хандив, санхүүгийн дэмжлэг үзүүлсэн аж ахуйн нэгж, байгууллагад татварын хөнгөлөлт олгоход тавигдах шаардлагыг хавсралт ёсоор баталсугай.

2.Дараах арга хэмжээг авч ажиллахыг доор дурдсан албан тушаалтнуудад тус тус даалгасугай:

2.1.энэ тушаалын хавсралтаар баталсан албан татварын хөнгөлөлтөд хамрагдах бүтээн байгуулалт, төсөл, үйл ажиллагаанд тавигдах шаардлагыг эрхлэх асуудал, бүс орон нутгийн хүрээнд сурталчилж, хэрэгжилтийг ханган ажиллахыг Төрийн захиргааны удирдлагын газар (С.Батзаяа), харьяа байгууллагын дарга, захирад нарт;

2.2.албан татварын хөнгөлөлтөд хамрагдсан аж ахуйн нэгж нь шаардлагыг хангаагүй нь тогтоогдсон тохиолдолд энэ талаар тухай бүр татварын албанад мэдэгдэж ажиллахыг Салбарын хөгжил, орон сууцжуулалтын бодлого, зохицуулалтын газар (Ц.Адъяабаатар)-т;

2.3.албан татварын хөнгөлөлтөд хамрагдсан бүтээн байгуулалт, төсөл, үйл ажиллагааны статистик мэдээллийг нэгтгэн хагас жил тутам тайлагнаж ажиллахыг Статистик, мэдээллийн сангийн хэлтэс (Н.Нарантуяа)-т.

3.Энэ тушаалын хэрэгжилтийг хангаж ажиллахыг Санхүү, хөрөнгө оруулалтын газар (Ц.Ариунсанаа)-т, гүйцэтгэл, үр дүнд хяналт тавьж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар (Х.Ган-Очир)-т тус тус үүрэг болгосугай.

4.Энэ тушаал гарсантай холбогдуулан “Хот байгуулалт, барилга, нийтийн аж ахуйн салбарт хөнгөлөлт эдлэх бүтээн байгуулалт, төсөл, үйл ажиллагаанд тавигдах шаардлага батлах тухай” Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайдын 2024 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн 133 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

САЙД

Ж.БАТСУУРЬ

ТӨСӨЛ

Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайдын 2024 оны сарын.....ныдугаар тушаалын нэгдүгээр хавсралт

ХОТ БАЙГУУЛАЛТ, БАРИЛГА, НИЙТИЙН АЖ АХУЙН САЛБАРТ ХӨНГӨЛӨЛТ ЭДЛЭХ БҮТЭЭН БАЙГУУЛАЛТ, ТӨСӨЛ, ҮЙЛ АЖИЛЛАГААНД ТАВИГДАХ ШААРДЛАГА

Нэг.Нийтлэг үндэслэл

1.1.Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.9-д заасан хөрөнгө оруулалт, хандив, санхүүгийн дэмжлэгт татварын хөнгөлөлт эдлэхэд энэхүү шаардлагыг баримтална.

1.2. Аж ахуй нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 22.9-д заасан хөнгөлөлт эдлэх бүтээн байгуулалт, төсөл, хөтөлбөр, үйл ажиллагаанд энэхүү шаардлага хамаарна.

Хоёр. Зорилго, хамрах хүрээ

2.1.Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.9.1-ээс 22.9.8, 22.10-д заасан бүтээн байгуулалт, төсөл, хөтөлбөр, арга хэмжээнд хөрөнгө оруулсан, санхүүгийн дэмжлэг, хандив олгосон татвар төлөгч аж ахуйн нэгж, байгууллагад татварын хөнгөлөлт үзүүлэхэд оршино.

2.2.Монгол Улсын нутаг дэвсгэрт Албан татвар төлөгчийн орлого олох үйл ажиллагаатай хамааралгүй, нийгмийн хариуцлагын хүрээнд шинээр барих барилга байгууламжийн барилгын болон тохижилттын ажил гүйцэтгэх, барилгын материал, бүтээгдэхүүн үйлдвэрлэх, нийлүүлэх, зураг төсөл, ТЭЗҮ боловсруулах, төсөл, хөтөлбөр үйл ажиллагаанд шаардлага хангасан хөрөнгө оруулалт хийсэн, хандив, санхүүгийн дэмжлэг олгосон аж ахуйн нэгж, байгууллага хамаарна.

Гурav. Нэр томьёоны тодорхойлолт

Энэ тушаалд хэрэглэсэн нэр томьёог доор дурдсан утгаар ойлгоно:

3.1. “бүтээн байгуулалтын төсөл, үйл ажиллагаа” гэж агаар, ус, хөрсний бохирдлыг бууруулах, нөөцийг нэмэгдүүлэх, барилгын материалын бүтээгдэхүүн үйлдвэрлэл нийлүүлэх, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан тохируулгатд орчин бүрдүүлэх, хүүхдийн тоглоомын талбай, зуслан, цэцэрлэгт хүрээлэн барьж байгуулах, тохижуулах, цэцэрлэгжүүлэхэд чиглэсэн бүтээн байгуулалтын төсөл, барилга байгууламж, үйл ажиллагааны иж бүрэн зураг төсөл, ТЭЗҮ, барилга байгууламж, инженерийн дэд бүтцийн шугам сүлжээний угсралтын ажлыг;

3.2.“нийтийн эзэмшлийн зам, талбай, цэцэрлэгт хүрээлэн барьж байгуулах” шаардлагын “нийтийн эзэмшлийн” гэж Газрын тухай хуулийн 3.1.9-т тодорхойлсон “нийтийн эдэлбэрийн газар”-аар хязгаарлахгүйгээр татвар төлөгч болон аливаа бусад этгээдийн өмчлөл, эзэмшил болон ашиглалтын талбайд

ТӨСӨЛ

олон нийтийн хэрэгцээнд зориулан зам, талбай, цэцэрлэгт хүрээлэнг шинээр барих, байгуулах үйл ажиллагааг;

3.3."бүтээн байгуулалт, төсөл, үйл ажиллагааны зураг төсөл" гэж Барилгын тухай хуулийн 4.1.30 заалт дахь "зураг төсөл"-ийн шаардлагыг хангасан байх бөгөөд холбогдох бусад хууль, дүрэм, журамд нийцүүлсэн, барилга байгууламжийг төлөвлөх, барилгын ажил гүйцэтгэхэд шаардагдах загвар зураг, эх загвар зураг /эскиз/, техник, эдийн засгийн үндэслэл, техникийн болон ажлын зураг, барилгын ажил гүйцэтгэх талбайн болон үйлдвэрлэлийн зохион байгуулалтын төсөл, инженер хайгуулын судалгаа, инженер геологи, геодезийн зураглал, инженерийн тооцоо, өргтийн төсөв зэрэг баримт бичгийн иж бүрдлийг;

3.4."техник, эдийн засгийн үндэслэл" гэж татварын хөнгөлөлт эдлэх бүтээн байгуулалтын төсөл, үйл ажиллагааны цар хүрээ, хөрөнгө оруулалтын хэмжээг тодорхойлсон баримт бичгийг;

3.5."бүтээн байгуулалтын төсөл" гэж нийгмийн болон инженерийн дэд бүтцийн барилга байгууламж, шугам сүлжээ, цэцэрлэгт хүрээлэнг барьж байгуулах урт хугацаанд үргэлжлэх үйл ажиллагааны санхүүгийн болон бүтээн байгуулалтыг үе шаттайгаар төлөвлөсөн, үргэлжлэх хугацаа, хөнгөлөлт эдлэх хуваарийг илэрхийлсэн цогц баримт бичгийг;

3.6."гадна тохижилтын ажил" гэж Барилгын тухай хуулийн 4.1.25 заалт дахь барилга байгууламжийн гаднах талбайн ногоон байгууламж, автозам, зогсоол, явган хүний зам, гарц, оршин суугчдын амрах болон хүүхдийн тоглоомын талбай, уран барилгын жижиг хэлбэр, гэрэлтүүлэг зэргийг барьж байгуулах үйл ажиллагааг;

3.7."засварын ажил" гэж барилгын үндсэн хийц, бүтээцийг өөрчлөхгүйгээр барилга байгууламжийг засварлах, түүнд суурилуулсан цэвэр, бохир ус, уур, хий, дулаан, цахилгаан, механик тоног төхөөрөмжийн техникийн үзүүлэлтийг бууруулахгүйгээр ашиглалтын хугацааг уртасгах зорилгоор элэгдэж хуучирсан, эвдэрсэн тоног төхөөрөмжийг солих зэрэг үйл ажиллагааг;

Дөрөв. Татварын хөнгөлөлт эдлэх үйл ажиллагаа, төсөл, арга хэмжээнд тавигдах нийтлэг шаардлага

4.1.Хөрөнгө оруулалт нь нийгмийн хариуцлагын хүрээнд Монгол Улсын нутаг дэвсгэрт ашгийн болон ашгийн төлөө бус хуулийн этгээд, хувь хүний элэгдэл тооцох үндсэн хөрөнгөд оруулсан санхүүгийн эх үүсвэр, биет болон биет бус хөрөнгө байна.

4.2.Хөрөнгө оруулалт нь дараах нийтлэг шаардлагыг хангасан байна:

4.2.1.татвар төлөгчийн хөрөнгө оруулалт хийсэн үйл ажиллагаа нь Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 8.1, 8.5-д заасан өөрийн үндсэн үйл ажиллагаатай хамааралгүй байх;

4.2.2.татвар төлөгч нь Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 13.1.1, 13.1.3, 13.1.4, 13.1.5-д заасан хасагдах зардлын шаардлагыг хангасан байх;

4.2.3.татвар төлөгч нь өөртөө хөрөнгө оруулалт хийсэн тохиолдолд аж ахуйн нэгжийн баталсан бизнесийн төлөвлөгөөнд туссан бодитой хийгдсэн байх;

4.2.4.татвар төлөгч нь бусад этгээдэд хөрөнгө оруулалт хийсэн тохиолдолд тухайн этгээдтэй хийсэн гэрээ, хүлээн авагч талын санхүүгийн тайланд элэгдэл тооцох үндсэн хөрөнгөөр бүртгэгдсэн байх;

4.2.5.татвар төлөгч нь тухайн ажлыг гүйцэтгэхээр гэрээнд заасан хугацаанд багтаан чанартай гүйцэтгэснийг баталсан үе шатны тайлан, акт ирүүлсэн байх;

4.2.6.нийгийн хариуцлагын хүрээнд оруулсан хөрөнгө оруулалтыг тайлант хугацааны санхүүгийн тайландаа тусгай дансанд бүртгэсэн байх;

4.3.Хөнгөлөлт эдлэх аж ахуйн нэгжийн төсөл нь хэд хэдэн салбарыг хамарсан байвал “Хөнгөлөлтөд хамрагдах цогцолбор бүтээн байгуулалт, төсөл, үйл ажиллагаа”-г зохицуулахаар гаргасан Хамтарсан тушаалд заасан албан тушаалтантай төсөл хэрэгжүүлэгч нь гэрээ байгуулна;

4.4.Энэхүү журмын дагуу Албан татварын хөнгөлөлт эдлэх аж ахуйн нэгжийн хэрэгжүүлэх төслийн мэдээллийг Хамтарсан тушаал заасан албан тушаалтан татварын албанд хүргүүлнэ;

4.5.Хуулийн 22 дугаар зүйлийн 22.9.1, 22.9.4 дэх хэсэгт заасан төслийн үйл ажиллагааны ашиглалт, хамгаалалтын зардлыг менежмент хариуцсан ашгийн төлөө бус хуулийн этгээдтэй гэрээ байгуулах замаар шийдвэрлэнэ;

4.6.Санхүүгийн дэмжлэг нь хувь хүн, хуулийн этгээдэд олгож байгаа биет болон биет бус хөрөнгөөс бүрдэнэ.

4.7.Хандив нь тодорхой зориулалтаар, үнэ төлбөргүй, эсхүл нийтэд санал болгож байгаа хөнгөлөлтөөс илүү хөнгөлөлттэй үнээр санхүүгийн эх үүсвэр, эд хөрөнгө шилжүүлэх болон үйлчилгээ үзүүлэх хэлбэртэй байна.

4.8.Санхүүгийн дэмжлэг, хандив нь дараах нийтлэг шаардлагыг хангасан байна:

4.8.1.хариу төлбөргүй шилжүүлсэн мөнгөн болон биет хөрөнгө байх Санхүүгийн дэмжлэг үзүүлэх, хандив олгох этгээд нь Татварын ерөнхий хуулийн 27 дугаар зүйлд заасны дагуу татвар төлөгчтэй харилцан хамааралгүй байх;

4.8.2.Иргэний хуульд заасан гэрээг үйлдэж баталгаажуулсан байх;

4.8.3.Энэхүү шаардлагын 4.8.2-т заасны дагуу байгуулсан гэрээг тухай бүр татварын албанд бүртгүүлсэн байх;

4.8.4. Санхүүгийн дэмжлэг, хандивын зардал нь Татварын ерөнхий хуулийн 28.5-д заасан дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримтаар баталгаажсан байна.

4.8.5 санхүүгийн дэмжлэг, хандив олгосон болон хүлээн авсан этгээд нь тухайн санхүүгийн дэмжлэг, хандивыг энэхүү шаардлага, стандартын 6.1.3-т заасан гэрээнд тусгасан зориулалтын дагуу тухайн тайлант хугацаанд зарцуулсан гэдгийг хүлээн зөвшөөрч, гэрээг цуцлах болон татгалзахгүй тухайгаа илэрхийлсэн акт үйлдэж, нотариатаар гэрчлүүлсэн байх;

4.9. Бүтээн байгуулалт, төсөл, арга хэмжээ нь салбарын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын баталсан шаардлагыг хангасан байна.

4.10. Хөрөнгө оруулалт хийсэн, санхүүгийн дэмжлэг, хандив олгосон татвар төлөгч нь татварын хөнгөлөлт эдлэхдээ татварын албанаас баталсан маягтын дагуу зардлыг Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 26.1, 26.2-т заасан тайландаа хавсаргаж тайлагнана.

Тав .Албан татварын хөнгөлөлт эдлэх бүтээн байгуулалт,

төсөл, арга хэмжээ

5.1. Татварын хөнгөлөлт эдлэх бүтээн байгуулалт, төсөл, арга хэмжээ нь дараах хүрээнд нийцсэн байна. Үүнд:

5.1.1. Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.9.1. заалт дахь агаар, ус, хөрсний бохирдлыг бууруулах, усны нөөцийг хамгаалах, нэмэгдүүлэх, зохистой ашиглах;

5.1.2. Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.9.2. хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан тохируулгад орчин бүрдүүлэх, хүүхдийн тоглоомын талбай, зуслан, цэцэрлэгт хүрээлэн барьж байгуулах;

5.1.3. Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.9.3. соёлын бүтээлч үйлдвэрлэлийн цогцолбор барьж байгуулах;

5.1.4. Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.9.4. нийтийн эзэмшлийн зам, талбай, цэцэрлэгт хүрээлэн барьж байгуулах, ашиглах, хамгаалах, тохижуулах, цэцэрлэгжүүлэх;

5.1.5. Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.9.6. спортын барилга байгууламж барьж байгуулах, ашиглах, олимпын төрлийн тэмцээн зохион байгуулах, Монголын үндэсний олимпын хорооны бүртгэлтэй олимпын төрлийн спортын холбоо, түүнд бүртгэлтэй баг, мэргэжлийн тамирчин, дасгалжуулагчид олгосон санхүүгийн дэмжлэг;

5.1.6. Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.9.7. Монгол Улсын Засгийн газраас зарласан тэргүүлэх чиглэлээр гадаадын их, дээд сургуульд, дотоодын магадлан итгэмжлэгдсэн их, дээд сургуульд суралцаж байгаа оюутан, мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын суралцагчид олгосон сургалтын төлбөрийн тэтгэлэг;

5.1.7. Энэ тушаалын хавсралтад заасан салбарын хүрээнд хамаарах, шаардлагад нийцсэн бусад арга хэмжээ.

Зургаа. Бүрдүүлэх баримт бичиг

6.1 Хөнгөлөлт эдлэх төсөл, хөрөнгө оруулалт, санхүүгийн дэмжлэг, хандив нь нийтлэг шаардлагыг хангасан байх бөгөөд дараах баримт бичгийг бүрдүүлсэн байна:

6.1.1.татвар төлөгчийн нийгмийн хариуцлагын хүрээнд Нийслэл Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээ, өөрийн эсхүл өөр хуулийн этгээдийн элэгдэл тооцох үндсэн хөрөнгөд оруулсан бодитой хөрөнгө оруулалтын хэмжээг нотлох баримт бичиг;

6.1.2.хуулийн 8.1, 8.5 дэх хэсэгт заасан үндсэн үйл ажиллагаатай хамааралгүйг нотлох баримт;

6.1.3.татвар төлөгчийн өөрийн хэрэгжүүлэх бүтээн байгуулалт, төслийн хувьд тухайн татвар төлөгчийн удирдах дээд байгууллагын баталсан бизнесийн төлөвлөгөөнд туссан, санхүүгийн тайланд элэгдэл тооцох үндсэн хөрөнгөөр бүртгэгдсэн байх;

6.1.4.татвар төлөгч бусад этгээдэд хөрөнгө оруулалт хийх тохиолдолд тухайн этгээдтэй төсөл, үйл ажиллагаанд нь хөрөнгө оруулалт хийх гэрээ байгуулж, гэрээг нотариатаар гэрчлүүлж, хөрөнгө оруулалт авч буй талын санхүүгийн тайланд элэгдэл тооцох үндсэн хөрөнгөөр бүртгэгдсэн санхүүгийн баримт;

6.1.5.татварын хөнгөлөлтөд хамрагдахыг хүссэн албан хүсэлт;

Долоо. Хяналт, баталгаажуулалт

7.1.Хөнгөлөлт эдлэх бүтээн байгуулалт, төсөл, үйл ажиллагаанд тавигдах шаардлагыг хангасан эсэхэд барилгын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хяналт тавина.

7.2.Татварын алба албан татварын хөнгөлөлтөд хамрагдахаар ирүүлсэн татвар төлөгчийн жилийн эцсийн татварын тайлангийн хөнгөлөлтийн мэдээллийг дараа оны 3 дугаар сарын 01-ний дотор цахим болон цаасан хэлбэрээр салбарын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хянуулахаар хүргүүлнэ.

7.3.Барилгын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь ирүүлсэн мэдээллийг ажлын 30 хоногийн дотор хянаж, хөнгөлөлтийн мэдээллийг баталгаажуулан өөрчлөлт орсон бол тайлбарын хамт татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ.

7.4.Барилгын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь шинээр үүссэн нөхцөл байдлын улмаас хөнгөлөлтөд хамрагдсан аж ахуйн нэгж нь шаардлагыг хангаагүй нь тогтоогдсон тохиолдолд энэ тухай татварын албанц мэдэгдэнэ. Татварын алба хууль тогтоомжийн дагуу холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

7.5.Нийгмийн хариуцлагын хүрээнд нэг ба түүнээс дээш жилийн хугацаанд хэрэгжих бүтээн байгуулалт, төслийг барилгын асуудал эрхэлсэн төрийн

захиргааны төв байгууллагад Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 22.13-т заасан маягтын дагуу бүртгүүлсэн байна.

Найм. Бусад

8.1. Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.9 дэх хэсгийг татвараас зайлсхийх үндсэн зорилгоор ашигласан тохиолдолд татварын хөнгөлөлтийг эдлүүлэхгүй.

8.2. Аж ахуйн нэгжийн оруулсан хөрөнгө оруулалт, санхүүгийн дэмжлэг, хандив нь нийгмийн хариуцлагын хүрээнд зарцуулагдаагүй, гэрээний хэрэгжилт хангалтгүй тохиолдолд татварын хөнгөлөлтөд бүртгэхгүй.